



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2022 оны 09 сарын 26 өдөр

Дугаар 68

Мандалговь

**Ерөнхий шалгалт зохион байгуулах  
комисс томилох тухай**

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.7, 33.12 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Төрийн албаны 2022 оны 10 дугаар сарын ерөнхий шалгалт зохион байгуулах комиссыг нэгдүгээр хавсралтаар, шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх багийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


Хоёр. “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол журам”-д заасан салбар комиссын чиг үүргийг хэрэгжүүлэн, шалгалтыг аймагт зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гарган, Төрийн албаны зөвлөлөөс өгсөн заавар зөвлөмжийн дагуу ерөнхий шалгалтыг бэлтгэл, зохион байгуулалт сайтай явуулах, тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад оруулах санал, холбогдох бусад материалыг Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлж ажиллахыг комисс (Ш.Төрбат)-т даалгасугай.

Гурав. Ерөнхий шалгалт зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөөний дагуу шалгалт зохион байгуулах танхим, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, Улсын онцгой комисс, Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн заавар зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг шалгалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх багийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ



Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн  
даргын 2022 оны ...09... дугаар сарын ...06...-ны  
өдрийн ...03... тоот тогтоолын нэгдүгээр хавсралт



ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Ш.Төрбат (Салбар зөвлөлийн даргын албан үүргийг түр орлон  
гүйцэтгэгч, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга)


Нарийн бичгийн дарга: С.Хулан (Салбар зөвлөлийн гишүүн, Салбар зөвлөлийн  
нарийн бичгийн дарга)

Гишүүд: Б.Мөнхбат (Салбар зөвлөлийн гишүүн, Цагдаагийн газрын дарга)

Б.Энхтуяа (Салбар зөвлөлийн гишүүн, Статистикийн хэлтсийн дарга)

С.Пүрэвсүрэн (Салбар зөвлөлийн гишүүн, төрийн захиргааны ахмад  
ажилтны төлөөлөл)

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн  
даргын 2022 оны ...09 дугаар сарын 26-ны  
өдрийн 68 тоот тогтоолын хоёрдугаар хавсралт



## ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Н.Мөнгөн (Аймгийн ЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан)
2. Н.Алтан-Од (Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан)
3. Д.Давхарбаяр (Аймгийн Цагдаагийн газрын хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа)
4. Б.Оюумаа (Сайнцагаан сумын Эрүүл мэндийн төвийн дарга, их эмч)
5. Д.Наранхүү (Тагнуулын ерөнхий газрын Дундговь дахь хэлтсийн ажилтан)